



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Тогтоол, журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, 6.3.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолд дор дурдсан агуулга бүхий долоодугаар хавсралт нэмсүгэй:

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны  
7 дугаар сарын 08-ны 211-р тогтоолын  
долоодугаар хавсралт

### ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧЭЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

№	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>			
1.1	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх этгээд /иргэн/	100,000 төгрөг	Жил бүр
1.2	Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх этгээд /иргэн/	100,000 төгрөг	Жил бүр
1.3	Үнэт металл болон үнэт чулууны арилжаа эрхлэх хуулийн этгээд	300,000 төгрөг	Жил бүр
1.4	Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх хуулийн этгээд	300,000 төгрөг	Жил бүр
<b>ХОЁР. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>			
2.1	Улаанбаатар хотод салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	100,000 төгрөг	Тухай бүр
2.2	Орон нутагт салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл	20,000 төгрөг	Тухай бүр
2.3	Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл	100,000 төгрөг	Тухай бүр

2.4	Тусгай зөвшөөрөл сэргээх	100,000 төгрөг	Тухай бүр
2.5	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000 төгрөг	Тухай бүр

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "... зургаадугаар хавсралтаар" гэсний дараа "Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг долоодугаар хавсралтаар" гэж нэмсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам"-ийн 3.3 дахь хэсгийн "...1, 2, 3, 4, 6" гэсний дараа "7" гэж нэмсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН